



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

### ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ

Аудитын код: ГАА-2022/01/-НА-СТА-ТЕЗ

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2021 ОНЫ  
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Алтай хот

2022 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр

Утас: 70483413 Цахим хаяг: [tuvshinbayarkh@audit.gov.mn](mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn)

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 70484055 Цахим хаяг: [erdenechimegd@audit.gov.mn](mailto:erdenechimegd@audit.gov.mn)

Ахлах аудитор: Ж.Бүжинханд

Утас: 99177546 Цахим хаяг: [Bujinkhandj@audit.gov.mn](mailto:Bujinkhandj@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган төгрөг/ .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган төгрөг/ .....	4
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөг/ .....	5
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөг/ .....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөг/ .....	6
3. Аудитын тайлан .....	9
3.1. Ерөнхий зүйл .....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал .....	10
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга .....	11
3.5.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө .....	11
3.5.2 Авлага .....	12
3.5.3 Урьдчилгаа .....	13
3.5.4 Бараа материал .....	14
3.5.5 Үндсэн хөрөнгө .....	15
3.5.6 Нийт өр төлбөр .....	16
3.5.7 Засгийн газрын хувь оролцоо .....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	17
3.8 Аудитын гол асуудал .....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татвартай холбоотой .....	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	19
4. Аудитын илрүүлэлт .....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	27
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	28
Төсвийн төвлөрүүлэн захирагч .....	28

### Товчилсон үгийн жагсаалт

АТҮГ	Алтайн тохижилт үйлчилгээний газар
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
НДШ	Нийгмийн даатгалын шийтгэл
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНТЕЗ	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар
ОНТҮГ	Орон нутгийн төсөвт үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
СХС	Сум хөгжүүлэх сан
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
МХС	Мал хамгаалах сан
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
ЖДҮХС	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
БХНСБХС	Байгаль хамгаалах нөхөн сэргээх барьцаа хөрөнгийн сан
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв

Дүрслэл, хүснэгтийн товчлол:

Хүснэгт №1. [Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл](#)

Хүснэгт №2: Төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Хүснэгт №3 Авлага дансны үлдэгдэл

Хүснэгт №4 Бараа материалын [үлдэгдэл](#)

Хүснэгт №5 Урьдчилгаа дансны [үлдэгдэл](#)

Хүснэгт №6 Үндсэн хөрөнгийн [үлдэгдэл](#)

Хүснэгт № 7: Нийт өр төлбөрийн [үлдэгдэл](#)

Хүснэгт № 8: Засгийн гарзын хувь оролцоо дансны үлдэгдэл

Хүснэгт № 9 : Үр дүнгийн орлого

Хүснэгт № 10: Үр дүнгийн зардал

Хүснэгт № 11: Нэгтгэсэн тайлангийн 2020 оны төсвийн гүйцэтгэл /хураангуй/

Хүснэгт №12: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шийдвэрийн төлбөрийн хэрэгжилт

График 1: Нийт өр төлбөр



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГА О.АМГАЛАНБААТАР ТАНАА

## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.04.20 № 194  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Төсвийн Ерөнхийлөн Захирагч нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.Х.ТҮВШИНБЯАР



07020540

## 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	34,671,930.9	43,403,531.7
31	Мөнгөн хөрөнгө	9,806,283.1	15,791,919.2
33	Авллага	13,078,395.7	14,026,752.2
34	Урьдчилгаа	151,160.6	164,212.6
35	Бараа материал	8,118,712.0	9,524,062.8
36	нөөцийн бараа	246,818.6	352,204.0
360	Бусад эргэлтийн хөрөнгө	3,270,561.0	3,544,380.9
<b>2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	148,156,078.3	161,124,254.6
39	Үндсэн хөрөнгө	148,156,078.3	161,124,254.6
39200	Биет хөрөнгө	142,104,474.6	154,962,919.7
39300	Биет бус хөрөнгө	6,051,603.7	6,161,334.9
<b>3</b>	<b>Нийт хөрөнгийн дүн III=I+II</b>	182,828,009.2	204,527,786.3
<b>4</b>	<b>Нийт өр төлбөр</b>	13,841,958.0	15,466,455.8
41	Богино хугацаат өр төлбөр	2,334,330.2	4,054,240.4
41200	Богино хугацаат зээлийн өглөг	18,079.2	31,748.8
41300	Өглөг	959,477.2	1,636,547.6
41400	Урьдчилж орсон орлого	1,356,773.7	2,385,944.0
42	Урт хугацаат өр төлбөр	11,507,627.8	11,412,215.4
42200	Урт хугацаат зээл	11,507,627.8	11,412,215.4
<b>5</b>	<b>Цэвэр өмчийн дүн</b>	168,986,051.2	189,061,330.5
51	Засгийн газрын хувь оролцоо	168,986,051.2	189,061,330.5
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	54,504,139.4	57,060,390.9
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	5,337,744.2	16,661,769.2
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	53,702.0	53,702.0
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	68,468,087.5	75,086,993.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	40,622,378.1	40,198,474.6
<b>6</b>	<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн VI=IV+V</b>	182,828,009.2	204,527,786.3

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	102,932,463.50	107,969,976.00
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	8,372,178.50	9,086,052.60
110	Орлогын албан татвар	6,737,382.30	7,272,326.20
1100	Хувь хүний орлогын албан татвар	7,121,669.30	7,686,434.70
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-384,287.00	-414,108.50
113	Хөрөнгийн албан татвар	591,580.10	754,944.50
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,043,216.10	1,058,781.90
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	88,739,259.00	84,609,585.60
120	Нийтлэг татварын бус орлого	27,800,638.20	20,002,014.60
121	Хөрөнгийн орлого	29,780.90	105,946.90
122	Тусламжийн орлого	33,365.50	24,435.20
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	60,875,474.30	64,477,188.80
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	5,821,026.00	14,274,337.80
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	73,145,229.90	83,122,722.10
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	73,145,229.90	83,122,722.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	68,961,139.80	80,174,077.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	38,541,451.20	41,457,877.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,789,265.40	5,467,880.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,741,735.30	6,326,651.50
2104	Хангамж, бараа материалын зардал	1,972,171.40	2,894,377.70
2105	Нормативт зардал	2,201,981.90	5,980,888.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	447,294.20	803,918.10

**Говь-Алтай аймгийн Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2107	Томилолт, зочны зардал	181,286.10	176,720.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,924,208.00	5,052,569.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,161,746.20	12,013,194.00
212	ТАТААС	16,352.70	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,167,737.40	2,948,644.30
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>29,787,233.70</b>	<b>24,847,253.90</b>
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>39,900.00</b>	<b>1,000.00</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>9,314,532.10</b>	<b>19,020,688.10</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>20,512,601.60</b>	<b>5,827,565.80</b>

**2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөг/**

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>81,052,360.60</b>	<b>94,909,886.00</b>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	8,372,178.50	9,086,052.60
110	Орлогын албан татвар	6,737,382.30	7,272,326.20
1100	Хувь хүний орлогын албан татвар	7,121,669.30	7,686,434.70
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-384,287.00	-414,108.50
113	Хөрөнгийн албан татвар	591,580.10	754,944.50
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,043,216.10	1,058,781.90
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	342,790.70	431,847.20
1181	Газрын төлбөр	490,373.30	373,770.70
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	205,026.60	250,741.40
1183	Бусад татвар	5,025.50	2,422.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	67,094,965.50	73,745,202.10
120	Нийтлэг татварын бус орлого	6,189,710.30	9,162,066.30
121	Хөрөнгийн орлого	29,780.90	105,946.90
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	60,875,474.30	64,477,188.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,585,216.60	12,078,631.30
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>66,358,312.20</b>	<b>72,471,685.00</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	66,358,312.20	72,471,685.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	62,167,175.40	69,474,078.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	39,616,961.10	42,414,357.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,124,525.60	5,855,313.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,236,220.50	6,719,211.90
2104	Хангамж, бараа материалын зардал	2,818,149.20	3,002,353.10
2105	Нормативт зардал	1,993,747.60	2,778,515.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	567,858.20	925,573.00
2107	Томилолт, зочны зардал	180,372.90	177,699.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,200,467.60	4,524,771.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,428,872.60	3,076,284.40
211	ХҮҮ	0	0
212	ТАТААС	23,000.00	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,168,136.80	2,997,606.80
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>14,694,048.50</b>	<b>22,438,201.10</b>
<b>IV</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>160,317.40</b>	<b>70,881.40</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>10,246,410.00</b>	<b>15,427,699.20</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,246,410.00	15,427,699.20
2200	Дотоод эх үүсвэрээр	10,246,410.00	15,427,699.20
2260	Гадаад эх үүсвэрээр	0	0
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-10,086,092.60</b>	<b>-15,356,817.80</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>-730,163.60</b>	<b>-1,095,747.10</b>
14	Бусад эх үүсвэр	76,050.00	91,267.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	742,350.00	1,097,183.00
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	63,863.60	89,831.10
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>3,877,792.30</b>	<b>5,985,636.20</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,928,490.80	9,806,283.10
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,806,283.10	15,791,919.20

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
<b>2019 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	143,923,173.8	0.0	143,923,173.8
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	19,710.2	0.0	19,710.2
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	143,942,884.1	0.0	143,942,884.1
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-28,120.9	0.0	-28,120.9
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	63,550.8	0.0	63,550.8
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
Өмчид гарсан өөрчилөлт	4,495,135.6	0.0	4,495,135.6
Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
Тайлант үеийн үр дүн	20,512,601.6	0.0	20,512,601.6
<b>2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	168,986,051.2	0.0	168,986,051.2
<b>2021 оны 1-р сарын 1-ны үлдэгдэл</b>	168,986,051.2	0.0	168,986,051.2
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,995,104.4	0.0	2,995,104.4
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	171,981,155.6	0.0	171,981,155.6
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-653,200.2	0.0	-653,200.2
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	36,026.6	0.0	36,026.6
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
Өмчид гарсан өөрчилөлт	11,869,782.7	0.0	11,869,782.7
Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
Тайлант үеийн үр дүн	5,827,565.8	0.0	5,827,565.8
<b>2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	189,061,330.5	0.0	189,061,330.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Төсвийн хэмнэлт, хэтрэлт	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	82,085,544.50	72,570,020.83	9,515,523.67	88%
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	67,039,432.70	64,514,983.13	2,524,449.57	96%
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	65,358,874.20	62,892,066.92	2,466,807.28	96%
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	40,884,786.60	40,161,688.20	723,098.40	98%
210101	Үндсэн цалин	33,467,445.60	32,387,473.24	1,079,972.36	97%
210102	Нэмэгдэл	2,107,774.80	2,519,847.59	(412,072.79)	120%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	187,085.10	318,295.90	(131,210.80)	170%
210104	Урамшуулал	2,656,377.70	2,573,393.06	82,984.64	97%
210105	Гэрээт ажлын хөлс	2,466,103.40	2,362,678.42	103,424.98	96%
2102	<b>Ажил олгогчдоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	5,553,859.10	5,288,811.31	265,047.79	95%
210201	Тэтгэврийн даатгал	3,918,847.30	3,729,952.75	188,894.55	95%
210202	Тэтгэмжийн даатгал	405,855.40	390,502.19	15,353.21	96%
210203	ҮОМШӨ-ний даатгал	332,411.00	313,974.86	18,436.14	94%
210204	Ажилгүйдлийн даатгал	81,736.20	77,217.21	4,518.99	94%
210205	Эрүүл мэндийн даатгал	815,009.20	777,164.31	37,844.89	95%
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	6,418,534.50	6,267,535.79	150,998.71	98%
210301	Гэрэл, цахилгаан	436,543.80	381,240.02	55,303.78	87%
210302	Түлш, халаалт	5,820,179.00	5,747,602.40	72,576.60	99%
210303	Цэвэр, бохир ус	161,811.70	138,693.38	23,118.33	86%
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,750,975.50	1,675,856.08	75,119.42	96%
210401	Бичиг хэрэг	208,236.50	199,683.89	8,552.61	96%
210402	Тээвэр, шатахуун	1,004,027.50	975,502.99	28,524.51	97%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	156,423.50	134,398.95	22,024.55	86%
210404	Ном, хэвлэл	60,601.20	57,704.22	2,896.98	95%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	54,692.80	46,616.88	8,075.92	85%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	266,994.00	261,949.15	5,044.85	98%
2105	<b>Нормативт зардал</b>	1,816,180.50	1,667,300.60	148,879.90	92%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	506,451.70	451,621.73	54,829.97	89%
210502	Хоол, хүнс	1,064,833.80	986,507.55	78,326.25	93%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	244,895.00	229,171.32	15,723.68	94%

**Говь-Алтай аймгийн Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,125,816.00	2,040,266.77	85,549.23	96%
210601	Багаж, техник, хэрэгсэл	905,253.00	835,794.56	69,458.44	92%
210602	Тавилга	497,383.50	487,932.06	9,451.44	98%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	17,190.00	16,177.05	1,012.95	94%
210604	Урсгал засвар	705,989.50	700,363.10	5,626.40	99%
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	194,978.20	135,652.65	59,325.55	70%
210702	Дотоод албан томилолт	194,578.20	135,252.65	59,325.55	70%
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	400.00	400.00	-	100%
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,774,035.70	2,949,475.04	824,560.66	78%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,647,773.60	2,850,283.18	797,490.42	78%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	29,280.60	21,082.40	8,198.20	72%
210803	Даатгалын үйлчилгээ	22,319.90	20,046.28	2,273.62	90%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	7,217.20	5,053.05	2,164.15	70%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	3,811.90	2,390.18	1,421.72	63%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	26,325.90	23,398.60	2,927.30	89%
210807	Газрын төлбөр	6,878.70	5,459.31	1,419.39	79%
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	9,441.90	5,401.62	4,040.28	57%
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	20,986.00	16,360.42	4,625.58	78%
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,839,708.10	2,705,480.49	134,227.61	95%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,605,936.30	2,480,433.94	125,502.36	95%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	233,771.80	225,046.55	8,725.25	96%
<b>212</b>	<b>ТАТААС</b>	20,000.00	20,000.00	-	100%
<b>2122</b>	<b>Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас</b>	20,000.00	20,000.00	-	100%
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	20,000.00	20,000.00	-	100%
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,660,558.50	1,602,916.20	57,642.30	97%
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,660,558.50	1,602,916.20	57,642.30	97%
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	98,400.00	82,800.00	15,600.00	84%
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	37,204.50	37,204.43	0.07	100%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	609,226.90	592,137.77	17,089.13	97%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	520,492.30	514,249.57	6,242.73	99%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	395,234.80	376,524.43	18,710.37	95%
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	12,956,991.50	6,957,854.73	5,999,136.77	54%
223001	Бусад хөрөнгө	12,956,991.50	6,957,854.73	5,999,136.77	54%
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	2,089,120.30	1,097,182.98	991,937.32	53%
230001	Эргэж төлөгдөх зээл	2,089,120.30	1,097,182.98	991,937.32	53%
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	82,085,544.50	76,676,225.41	5,409,319.09	93%
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	40,403,986.80	39,771,397.25	632,589.55	98%
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	40,403,986.80	39,771,397.25	632,589.55	98%
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	35,780,377.60	34,466,175.16	1,314,202.44	96%
320001	Орон нутгийн төсвөөс	25,701,015.80	24,386,813.41	1,314,202.39	95%
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	10,079,361.80	10,079,361.75	0.05	100%
<b>33</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	382,144.90	119,568.64	262,576.27	31%
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	382,144.90	119,568.64	262,576.27	31%
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	5,519,035.20	2,319,084.36	3,199,950.84	42%
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	523,802.10	1,855,783.49	(1,331,981.39)	354%
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	985,744.40	463,300.87	522,443.53	47%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	4,484,746.46	(4,484,746.46)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	8,590,928.03	(8,590,928.03)	

**2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан /мянган төгрөг/**

Код	Үзүүлэлт	ТЕЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,658,951.6</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,618,031.6</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,820,643.6</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>569,573.9</b>
210101	Үндсэн цалин	355,579.9
210102	Нэмэгдэл	61,312.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	234.0
210104	Урамшуулал	110,878.7
210105	Гэрээт ажлын хөлс	41,568.7
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>67,823.8</b>
210201	Тэтгэврийн даатгал	64,980.4
210202	Тэтгэмжийн даатгал	638.7

**Говь-Алтай аймгийн Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210203	ҮОМШӨ-ний даатгал	623.7
210204	Ажилгүйдлийн даатгал	161.2
210205	Эрүүл мэндийн даатгал	1,419.8
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>5,555.6</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,284.6
210302	Түлш, халаалт	2,722.0
210303	Цэвэр, бохир ус	549.1
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>224,097.9</b>
210401	Бичиг хэрэг	34,797.2
210402	Тээвэр, шатахуун	115,146.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,582.2
210404	Ном, хэвлэл	12,259.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,375.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	47,938.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,112,743.0</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	892,288.5
210502	Хоол, хүнс	120,368.3
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	100,086.3
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>261,132.4</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	158,879.1
210602	Тавилга	14,534.1
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,010.0
210604	Урсгал засвар	86,709.1
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>41,647.4</b>
210702	Дотоод албан томилолт	40,797.4
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	850.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,188,689.8</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,179,552.1
210803	Даатгалын үйлчилгээ	1,260.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	290.1
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5,210.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,377.6
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>349,379.8</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	252,396.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	96,983.2
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>797,388.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>581,107.1</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	581,107.1
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>216,280.9</b>
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжил төвлөрүүлэх шилжүүлэг	79,911.6
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	136,369.3
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>40,920.0</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>40,920.0</b>
223001	Бусад хөрөнгө	23,910.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	17,010.0
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>4,754,058.3</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>4,754,058.3</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	678,907.4
131103	ЗГНХ,ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	132,083.1
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,545,286.5
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	549,452.8
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	1,848,328.4
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>95,106.7</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	95,106.71

### 3. Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох, шилэн данс, төсвийн хэмнэлтийн горимтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитор Э.Сүнжидмаа, С.Санчирмаа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь төрийн аудитын газарт 2021 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн 1/390 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд аймгийн Засаг даргын бүрэн эрхийг тодорхойлсон.

Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг баталсан байна. Дараах зорилтын хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон байна. Үүнд:

- Ковид-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогыг хэрэгжүүлнэ.
- Амьдралын хэв маягаас үүдэлтэй өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлж, хүний хөгжлийг дэмжинэ.
- Төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж, үр ашгийг нэмэгдүүлнэ.
- Төрийн үйлчилгээг цахим болгон, авлига, ашиг сонирхлын зөрчил, гэмт хэрэг, болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх, батлан хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж, иргэний оролцоотой, нээлттэй, ил тод, хариуцлагатай засаглалын бодлого хэрэгжүүлнэ.
- Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Аймгийн төв болон сумдад цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэн, өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг дотоодоос бүрэн хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Бусад холбогдох хууль, тогтоомж

Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг 2020 онд баталсан. Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн чиг үүргийн байгууллагаас бусад байгууллагад даалгасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг шинэчлэн тогтоожээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

ТЕЗ-ийн дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын алба нь 2021 онд аймгийн ТЕЗ-ийн харьяаны нэгж байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаа, Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд төлөвлөгөөний дагуу дотоод аудит хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн ТЕЗ-ийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн болох 73,145.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 1,462.9 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардал 83,122.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 1,662.4 сая төгрөгөөр тооцсон. АДБОУС 2320-н 13-д зааснаар санхүүгийн тайланд анхлан тогтоосноос бага материаллаг байдал зохистой тул гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 9,806.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 15,791.9 сая төгрөг болж, 5,985.6 сая төгрөгөөр өссөн байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос өссөн нь төсөвт байгууллагын харилцахын үлдэгдэл 308.3 сая төгрөг, төсөл сангийн үлдэгдэл 5,063.3 сая төгрөг, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагын үлдэгдэл 847.4 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой. Харин төрийн сангийн үлдэгдэл 233.4 сая төгрөгөөр буурсан.

Тайлант оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 91.5 хувь буюу 14,455.0 сая төгрөг нь төрийн сангийн харилцах дансанд, 8 хувь буюу 1,334.6 сая төгрөг нь арилжааны банк дахь харилцах дансанд, 0.5 хувь буюу 2.3 сая төгрөг нь байгууллагуудын кассын дансанд байршиж байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	0.5	2.3	1.8
Төрийн сангийн харилцахад байгаа мөнгө	9,319.7	14,455.0	5,135.3
Банканд байгаа бэлэн мөнгө	486.1	1,334.6	848.5
<b>Дүн</b>	<b>9,806.3</b>	<b>15,791.9</b>	<b>5,985.6</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр харуулбал</i>			
Төрийн сан	3,919.2	3,685.8	(233.4)
Төсөвт байгууллага	21.6	329.9	308.3
Төсөл сан	5,400.5	10,463.8	5,063.3
ОНӨААТҮГ	465.0	1,312.4	847.4
<b>Дүн</b>	<b>9,806.3</b>	<b>15,791.9</b>	<b>5,985.6</b>

Эх сурвалж: Говь-Алтай аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Жилийн эцсийн кассын дансны 2.3 сая төгрөгийн үлдэгдлийн 74 хувь буюу 1.7 сая төгрөг нь “Нийтлэг үйлчилгээ” ОНТҮГ, 13 хувь буюу 0.3 сая төгрөг нь “Гэгээн нуур цэвэр ус” ААТҮГ, 12 хувь буюу 0.3 сая төгрөг нь “Ундарга-Алтай” ОНӨААТҮГ, 1 хувь буюу 0.02 сая төгрөг нь Соёл урлагийн газрын үлдэгдэл байна.

#### Төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 3,919.2 сая төгрөг байсан бол тайлант оны эцэст 3,685.8 сая төгрөг болж 233.4 сая төгрөгөөр буурсан.

#### Төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгө

Төсөвт байгууллагуудын мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 21.6 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 329.9 сая төгрөг болж, 308.3 сая төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн байгууллагуудын дансны үлдэгдлийг төвлөрүүлээгүйтэй холбоотой.

#### Төсөл сангийн мөнгөн хөрөнгө

Төсөл сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 5,400.5 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 10,443.1 сая төгрөг болж, 5,042.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Ковид-19 цар тахал гарснаас ОНХС-гийн хөрөнгөөр хийхээр төлөвлөсөн ажил хийгдээгүйтэй холбоотой.

Хүснэгт №2: Төсөл сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Банк дахь байгаа бэлэн мөнгө	
			Арилжааны банк	Төрийн сангийн харилцах
ОНХС	2,942.7	6,442.4		6,442.4
СХС	1,165.2	1,635.9		1,635.9
БХНСС	182.9	204.3		204.3
МХС	219.7	210.9		210.9
ТЭДС	39.4	9.1		9.1
ЖДҮДС	107.2	57.9		57.9
Халамжийн сан	0.02	0		0
Хөрөнгө оруулалт	743.2	1,882.6		1,882.6
<b>дүн</b>	<b>5,400.5</b>	<b>10,443.1</b>		<b>10,443.1</b>

Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

#### ОНӨААТҮГ-ын мөнгөн хөрөнгө

Тайлант онд ОНӨААТҮГ-уудын мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 465.0 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 1,312.4 сая төгрөг болж 847.4 сая төгрөгөөр өссөн нь “Алтай орон сууцны корпораци” ААТҮГ-ын дансанд үлдэгдэлтэй байсан орон сууцны төлбөр төвлөрсөнтэй холбоотой байна.

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын мөнгөн хөрөнгөтэй холбоотой дараах зөрчил илэрсэн.

Үүнд:

- ✓ Нэмэлт орлогыг 24.3 сая төгрөгийн зөвшөөрөлгүй олсон.
- ✓ Арилжааны банкинд 0.01 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй.
- ✓ Батлагдсан орон тоо, цалингийн зардал, албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас төсөв хохирсонтой холбоотой 283.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн.
- ✓ Цахилгаан, халаалт, цэвэр бохир усны төлбөр, хураамжийг төрөөс 18.7 сая төгрөгийн зөрүүтэй нэхэмжлэн авсан.
- ✓ Хоолны зардлыг нормативаас 5.7 сая төгрөгөөр илүү зарцуулсан.
- ✓ Засаг даргын нөөц хөрөнгө, мөрийн хөтөлбөрийн зардлыг зориулалт бусаар, шийдвэргүй 86.9 сая төгрөгийн зарцуулсан.
- ✓ Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн хэрэгжилттэй холбоотой 847.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

#### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 13,078.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 14,026.7 сая төгрөг болж, 948.3 сая төгрөгөөр өссөн.

Авлага дансны үлдэгдлийн 45 хувь нь ОНӨААТҮГ-ын, 48 хувь төсөвт байгууллагын, 4 хувь төсөл сангийн, 3 хувь нь УИХ-ын гишүүдийн олгосон зээлийн авлага тус тус эзэлж байна.

“Алтай орон сууцны корпораци” ААТҮГ-ын орон сууцны зээлтэй холбоотой 5,955.8 сая төгрөгийн авлага нь ТЕЗ-ийн нэгтгэсэн тайлангийн авлагад ихээхэн хэмжээгээр нөлөөлж байна.

Мөн цалингийн нөхөн олговортой холбоотой өмнөх оны 279.5 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй, тайлант онд нэмж 109.7 сая төгрөгийн нөхөн олговор нэмж олгосон нь авлага нэмэгдэх шалтгаан болж байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт дутуу олгосноос эрүүл мэндийн байгууллагуудын авлага нэмэгдсэн.

Хүснэгт №3 Авлага дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая.төгрөг/ Өсөлт+, бууралт-
Ажиллагчидтай холбогдсон авлага	55.2	47.5	7.7
Төлбөртэй үйлчилгээний авлага	-	1,936.8	1,936.8
Татаас, санхүүжилтийн авлага	-	-	-
Зээлийн хүүгийн авлага	174.6	104.8	69.8
Дансны авлага /ТӨҮГ/	6,515.9	5,669.9	(846.0)
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	0.5	24.9	24.4
Бусад авлага	2,584.0	2,796.3	212.3
Зээлийн авлага	3,748.2	3,446.5	(301.7)
<b>дүн</b>	<b>13,078.4</b>	<b>14,026.7</b>	<b>948.3</b>
<b>Үүнээс байгууллагын төрлөөр</b>	-	-	-
Төсөвт байгууллага	616.6	2,912.2	2,295.6
Төсөл/сан	4,831.4	4,321.6	(509.8)
Төрийн сан	564.0	510.0	(54.0)
ТӨҮГ болон ОНӨҮГ	7,066.4	6,282.9	(783.5)
<b>дүн</b>	<b>13,078.4</b>	<b>14,026.7</b>	<b>948.3</b>

Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын авлагатай холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- ✓ Авлага, өглөгийн барагдуулаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, эзэн холбогдогч нь тодорхойгүй 472.3 сая төгрөгийн зөрчил байна.
- ✓ Санхүүгийн тайлан дахь татварын авлага өглөг нь татварын тодорхойлолтоос 1,043.3 сая төгрөгийн зөрүүтэй.
- ✓ Сум хөгжүүлэх сангийн зээлдэгчийн гэрээний хугацаа дууссан байхад 177.6 сая төгрөгийн үндсэн төлбөр, хүүг төлүүлээгүй.
- ✓ Зээлийн гэрээний хугацаа дууссан зээлдэгчдээс зээлийг Шүүхэд хандаж шийдвэр гаргуулаагүй.
- ✓ Эвлэрлийн гэрээний хугацаа дууссан зээлдэгчийн авлага 127.6 сая төгрөгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай гэрээ байгуулан барагдуулах арга хэмжээ аваагүй.
- ✓ Монгол банкны зээлийн мэдээллийн санд Сум хөгжүүлэхийн сангийн зээлийн мэдээллийг 130.4 сая төгрөгийн зөрүүтэй оруулсан.
- ✓ Хөгжлийн банкинд гэрээний дагуу 1,670.1 сая төгрөгийг төлөөгүй.

### 3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансанд тайлант онд 164.2 сая төгрөг бүртгэгдэж өмнөх оноос 13.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	149.0	164.2	15.2
Цалингийн урьдчилгаа	2.2	0.01	(2.2)
<b>Дүн</b>	<b>151.2</b>	<b>164.2</b>	<b>13.0</b>
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>			
Төсөвт байгууллага	2.2	0.01	(2.2)
ОНӨААТҮГ	149.0	164.2	15.2
<b>Дүн</b>	<b>151.2</b>	<b>164.2</b>	<b>13.0</b>

Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэлд 164.2 сая төгрөг байгаа нь аймгийн Засаг дарга дансны 15.2 сая төгрөгийн баримтат киноны урьдчилгаа, аймгийн ИТХ-ын 0.01 сая төгрөгийн цалингийн урьдчилгаа, “Солонго дулааны станц” ААТҮГ-ын 149.0 сая төгрөгийн шугам сүлжээний ажлыг улсын комисс хүлээж аваагүйтэй холбоотой байна.

### 3.5.4 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 13,911.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 9,524.1 сая төгрөг болж, 4,387.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Бараа материалын үлдэгдэл

/сая.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
Түүхий эд материал	1,333.6	1,956.1	622.5
Бэлэн бүтээгдэхүүн	101.8	210.1	108.3
Хангамжийн материал	4,577.3	5,292.1	714.8
Биологийн хөрөнгө	1.7	23.3	21.6
Мал амьтад	2,104.3	2,042.5	(61.8)
Нөөцийн бараа	246.8	352.2	105.4
<b>дүн</b>	<b>8,365.5</b>	<b>9,876.3</b>	<b>1,510.8</b>
<b>Үүнээс байгууллагын төрлөөр</b>			
Төсөвт байгууллага	8,122.8	9,547.0	1,424.2
Төсөл/сан	5.7	7.7	2.0
Төрийн сан	-	-	-
ТӨҮГ болон ОНӨҮГ	237.0	321.6	84.6
<b>дүн</b>	<b>8,365.5</b>	<b>9,876.3</b>	<b>1,510.8</b>

Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 9,609.2 сая төгрөгийн, хандиваар 3,031.0 сая төгрөгийн, дотооддоо 195.9 сая төгрөгийн, бүтцийн өөрчлөлтөөр 171.1 сая төгрөгийн бараа материал тус тус шилжүүлэн авч, бусад эх үүсвэрээс 1,109.0 сая төгрөгийн бараа материал хүлээн авч нийт 14,116.3 сая төгрөгийн бараа материал нэмэгдсэн.

Тайлант онд бараа материалаас 12,145.3 сая төгрөгийг зарцуулж, 113.6 сая төгрөгийг дотооддоо, 22.9 сая төгрөгийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн, 323.8 сая төгрөгийг акталж нийт 12,605.5 сая төгрөгийн бараа материал хасагдаж тайлант оны эцэст 9,876.3 сая төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын бараа материалтай холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- ✓ Жолоочийн замын хуудасгүй, тооцоо бодолгүйгээр шатахуун зарцуулсан байх, албаны бус хэрэгцээнд 185.5 сая төгрөгийг зарцуулсан.
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй 757.8 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан.

### 3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 148,156.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 161,124.2 сая төгрөг болж 12,968.1 сая төгрөгөөр өссөн.

Хүснэгт №6 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	182,637.5	154,962.9	(27,674.6)
Хуримтлагдсан элэгдэл	(40,533.0)	(46,822.5)	6,289.5
Биет бус хөрөнгө	6,335.2	6,161.3	(173.9)
Хуримтлагдсан элэгдэл	(283.6)	(314.0)	30.4
<b>Дүн</b>	<b>148,156.1</b>	<b>161,124.2</b>	<b>12,968.1</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	156,279.7	163,549.7	<b>7,270.0</b>
Төсөвт байгууллагын хуримтлагдсан элэгдэл	(31,954.9)	(37,020.3)	<b>(5,065.4)</b>
Төсөл/Сан	104.3	98.7	<b>(5.6)</b>
Төсөл/Сан-ийн хуримтлагдсан элэгдэл	(57.9)	(53.6)	<b>4.3</b>
ОНӨААТҮГ-ууд	32,588.6	44,612.4	<b>12,023.8</b>
ОНӨААТҮГ-уудын хуримтлагдсан элэгдэл	(8,803.7)	(10,062.7)	<b>(1,259.0)</b>
<b>Дүн</b>	<b>148,156.1</b>	<b>161,124.2</b>	<b>12,968.1</b>

Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт хөрөнгийн 96 хувийг биет хөрөнгө, 4 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 1,908.4 сая төгрөгийн, хандив тусламжаар 6,370.1 сая төгрөгийн, дотооддоо 11,954.1 сая төгрөгийн, бүтцийн өөрчлөлтөөр 7,348.0 сая төгрөгийн, бусад эх үүсвэрээс 5,419.2 сая төгрөгийн, дахин үнэлгээний нэмэгдлээр 31.9 сая төгрөгийн, нийт 33,031.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн.

Үндсэн хөрөнгө данснаас 41.3 сая төгрөгийн хөрөнгийг худалдан борлуулж, 3,211.2 сая төгрөгийн хөрөнгийг акталж устган, дотооддоо 9,343.8 сая төгрөгийн, бүтцийн өөрчлөлтөөр 61.3 сая төгрөгийн хөрөнгийг тус тус шилжүүлэн, бусад эх үүсвэрээс 920.4 сая төгрөгийн, дахин үнэлгээний хорогдлоор 165.5 сая төгрөгийн, нийт 13,743.7 сая төгрөгийн хөрөнгө хасагдаж, эцсийн үлдэгдэл 161,124.2 сая төгрөг байна. Үүнээс хуримтлагдсан элэгдэл 47.1 сая төгрөг, үлдэгдэл өртөг 161,124.2 сая төгрөг байна.

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгөтэй холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- ✓ Хөрөнгийн тооллого хийгээгүй, тооллогын комиссын гарын үсгээр баталгаажуулаагүй 2,090.9 сая төгрөгийн зөрчил гарсан.
- ✓ Тайлант онд 361.1 сая төгрөгийн мал амьтдыг тоолоогүй, гэрээг дүгнээгүй, гэрээний хугацаа дууссан байхад дараагийн өрхөд хүлээлгэж өгөөгүй.
- ✓ Аймгийн ИТХ-ын хөрөнгө актлах шийдвэрт 66.7 сая төгрөгийн хөрөнгийг үнийн зөрүүтэй гаргасан.
- ✓ Тайлант онд автомашины засварт ихээхэн хэмжээний зардал гаргасан боловч хөрөнгийг эзэмшигчдэд нь давуу эрхээр шилжүүлсэн, 183.7 сая төгрөгийн үлдэх өртөгтэй автомашин акталсан.
- ✓ Тооллогоор 9.1 сая төгрөгийн хөрөнгө дутагдсан бодитоор байхгүй.
- ✓ Хугацаа дууссан үндэслэлээр 9.5 сая төгрөгийн эм акталсан.

### 3.5.6 Нийт өр төлбөр

Тайлант онд нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 13,842.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 15,466.3 сая төгрөг болж, 1,624.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7: Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая.төгрөг/


Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+, бууралт-
Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,334.4	4,054.2	1,719.8
Урт хугацаат өр төлбөрийн дүн	11,507.6	11,412.2	95.4
<b>Нийт өр төлбөрийн дүн</b>	<b>13,842.0</b>	<b>15,466.4</b>	<b>1,624.4</b>
<b>Үүнээс байгууллагын төрлөөр</b>	-	-	-
Төсөвт байгууллага	415.1	872.8	457.7
Төсөл/сан	856.2	2,016.4	1,160.2
ТӨҮГ болон ОНӨҮГ	12,570.7	12,577.2	6.5
<b>Нийт өр төлбөрийн дүн</b>	<b>13,842.0</b>	<b>15,466.4</b>	<b>1,624.4</b>

Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өр төлбөрийн 74 хувийг урт хугацаат өр төлбөр, 26 хувийг богино хугацаат өр төлбөр эзэлж байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд МОН-2301, МОН-1847 төслийн хүрээнд хийгдсэн хөрөнгө оруулалттай холбоотой “Ундарга-Алтай” ОНӨААТҮГ-ын 4,694.4 сая төгрөгийн зээл, “Солонго дулааны станц” ААТҮГ-ын 37.2 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл, “Алтай орон сууцны корпораци” ААТҮГ-ын 6,680.6 сая төгрөгийн нийт 11,412.2 сая төгрөгийн зээл байна.

#### График 1: Нийт өр төлбөр /байгууллагын төрлөөр/



Өмнөх онтой харьцуулж харихад төсөвт байгууллага, төсөл сан, ОНӨААТҮГ-ын өр төлбөр өссөн байна.

Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 168,986.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 189,061.3 сая төгрөг болж, 20,075.3 сая төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай байна.

- Тайлант онд шинээр үүсгэн байгуулагдсан “Алтай хотын тохижилт үйлчилгээний газар”-ын 8,884.9 сая төгрөг, “Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар”-ын 4,236.1 сая төгрөг, Есөнбулаг сумын “11-р цэцэрлэг”-ийн 3,355.1 сая төгрөг, “Алтай хотын Цогц үйлчилгээний газар”-ын 1,873.5 сая төгрөг, “Говь-Алтай аймгийн Инноваци бизнес хөгжлийн төв”-ын 91.1 сая төгрөг, “Соёлын хэлтэс”-ын 14.0 сая төгрөгийн хөрөнгөтэй байгууллагууд нэмэгдсэн байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн шугам сүлжээний ажлыг 10,268.0 сая төгрөгөөр “Солонго Дулааны станц” ААТҮГ-т бүртгэсэн.
- “Ундарга Алтай” ОНӨААТҮГ-ын 1,373.4 сая төгрөгөөр өссөн нь бохир усны шугам, худгийн таг зэрэг хөрөнгө оруулалтын ажлыг шинээр бүртгэсэн.

Хүснэгт № 8. Засгийн газрын хувь оролцоо

/сая. төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/
Засгийн газрын сан	59,895.6	73,775.9	13,880.3
Хуримтлагдсан үр дүн	68,468.1	75,086.9	6,618.8
Өмнөх үеийн үр дүн	68,468.1	69,259.4	791.3
Тайлант оны үр дүн	0.0	5,827.5	(5,827.5)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	40,622.4	40,198.5	(423.9)
<b>Дүн</b>	<b>168,986.0</b>	<b>189,061.3</b>	<b>20,075.3</b>

Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх үеийн үр дүн 791.3 сая төгрөгөөр өссөн нь өмнөх оны үр дүнд бичилт хийсэнтэй холбоотой байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 423.9 сая төгрөгөөр буурсан нь “0” үлдэгдэлтэй хөрөнгийг шийдвэр гарган данснаас хассанаар дахин үнэлгээний нэмэгдэл данс буурсан байна.

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн зардлыг бүлгийн дүнгээр хэтрүүлэн зарцуулаагүй байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.1 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн мэдээллийг энэ тайлангийн 2.6-д харуулав.

Орон нутгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилтийн талаарх мэдээллийг дэлгэрэнгүй тайлагнасан болно.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагад тайлант хугацаанд түүвэрлэн үзсэн шилэн дансны цахим системд оруулбал зохих 1 төрлийн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагад тайлант хугацаанд түүвэрлэн үзсэн шилэн дансны цахим системд оруулбал зохих 1 төрлийн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт, авлага, өглөгийн шийдвэрийг мэдээлээгүй, хоцроосон 97 байгууллагад шийдвэр өгсөн.

ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд түүвэр хийгдэж байгаа Олон нийтийн Алтай радио нь тайлант хугацаанд түүвэрлэн үзсэн шилэн дансны цахим системд оруулбал зохих 1 төрлийн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 82.1 сая төгрөгийн орлогын 12 гүйлгээг мэдээлээгүй байна.

Сум дундын ойн анги нь тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 46 мэдээллээс цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 төрлийн 11.0 сая төгрөгийн зарлагын гүйлгээг байршуулаагүй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### **3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татвартай холбоотой**

ТЕЗ-ийн харьяа нэгж, байгууллагууд 847.3 сая төгрөгийн И баримтгүй гүйлгээ хийснийг аудитаар шийдвэр өгчээ.

ТЕЗ-ийн нэгтгэсэн тайлангийн түүвэрт хамрагдаж байгаа байгууллагууд нь тайлант онд аж ахуйн нэгж, байгууллагаас худалдан авалт хийхдээ И-баримтгүй 15.5 сая төгрөгийн гүйлгээ хийснээс аудитын явцад 4.2 сая төгрөгийн төлбөрийн баримтыг нөхөн шивүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т заасан заалттай нийцэхгүй байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд :**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 1,212.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 3,075.8 сая төгрөгийн зөвлөмжийг хүргүүлжээ.

Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг давтан тооцоолоход албан шаардлагаас 117.3 сая төгрөгийг хэрэгжүүлсэн, 390.1 сая төгрөгийг Говь-Алтай аймгийн Сум дундын иргэний анхан шатны Шүүхэд нэхэмжлэл гаргасан, 705.0 сая төгрөгийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Зөвлөмжөөс 2 заалт бүхий 3,075.8 сая төгрөгийг хэрэгжүүлсэн, татварын тодорхойлолтын зөрүүг арилгах зөвлөмжийн хувьд Татварын хэлтэс шалгаж байна. ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын шийдвэрийг хэрэгжүүлэх зөвлөмж 77 хувьтай хэрэгжсэн байна.

Хэрэгжээгүй шийдвэрийн тухайд байгууллагын удирдлагад биелэлт ирүүлэх албан бичиг хүргүүлсэн төдийгүй холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулсан байна. Цаашид санхүүгийн ажилтны хариуцлагыг сайжруулан зөрчлийг давтан гаргахгүй байж өмнөх аудитын шийдвэрийг хангаж ажиллах нь зүйтэй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитын шийдвэрийг хэрэгжилт, авлага, өглөгийн барагдуулалт, аж ахуйн нэгж байгууллагын ашигт ажиллагааны түвшин, өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилтийг үзэх нь зүйтэй.

## 4. Аудитын илрүүлэлт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 156 төсвийн байгууллага, 61 тусгай сан, 21 төрийн сан, 13 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нийт 251 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 159 нэгж, байгууллагад дүгнэлт гаргаж, 90 нэгж, байгууллагын ажил гүйлгээг түүвэрт хамруулсан. Харин 2 байгууллага аудитад хамрагдаагүй.(Есөнбулаг сумын ЗДТГ, Орон сууцны алба ОНӨААТҮГ)

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 86, “Хязгаарлалттай” 72, Сөрөг 1 дүгнэлт өгсөн байна.

### Дүгнэлт гарсан нэгж байгууллагын аудитын илрүүлэлт:

ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг аудитын дүгнэлт гарсан нэгж байгууллагуудад 16,889.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 5,894.5 сая төгрөгийн алдааг залруулж, 547.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон, 10,330.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 10.0 сая төгрөгийн 110 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Аудитаар өгөгдсөн шийдвэрийг чанартай биелүүлж, нотлох баримтаар дэмжигдсэн хэрэгжилтийг өгөгдсөн хугацаанд ирүүлэхийг анхаарах хэрэгтэй.

### Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 1,316.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 823.7 сая төгрөгийн алдааг залруулж, 11.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон, 481.2 сая төгрөгийн 22 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 7 зөвлөмжийг хүргүүллээ.

### 4.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн залруулга

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн түүвэрт хамрагдсан байгууллагуудын санхүүгийн тайланд залруулга хийгдсэн. Аймгийн орон нутгийн орлогын хувьд Чандмань сумын ИТХ-ын тогтоолоор баталсан орлогын төлөвлөгөөг ТЕЗ-ийн тайланд 8.6 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн.

### Түүвэрт хамрагдсан байгууллагын тайланд хийгдсэн залруулга:

Мал хамгаалах сан нь санхүүгийн тайланд 1.8 сая төгрөгийн авлагыг зөрүүтэй илэрхийлснийг аудитаар залруулснаар нэгтгэсэн тайланд өөрчлөлт орсон.

Тариалан эрхлэлтийг дэмжих сан нь санхүүгийн байдлын тайланд 685.2 сая төгрөгийн хөрөнгийг зөрүүтэй бүртгэснийг аудитаар залруулснаар нэгтгэсэн тайланд өөрчлөлт орсон.

Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан нь санхүүгийн байдлын тайланд 117.6 сая төгрөгийн авлага зөрүүтэй илэрхийлснийг аудитаар залруулснаар нэгтгэсэн тайланд өөрчлөлт орсон.

Засаг даргын тамгын газрын 2 дугаар тайлангийн аудитаар иргэн аж ахуйн нэгж байгууллагаас худалдан авалтын 10.3 сая төгрөгийн и баримтыг нөхөн шивүүллээ.

### 4.2 Төлбөрийн акт

#### Тариалан эрхлэлтийг дэмжих сан

Зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төвлөрүүлбэл зохих 6.3 сая төгрөгийн үндсэн зээл, 0.7 сая төгрөгийн хүүг төлүүлээгүй нь аймгийн тариалан эрхлэлтийг дэмжих сангаас олгох зээлийн гэрээний 3.6-т "Зээлдэгч зээлийг сар бүрийн хуваарьт хоногийн ажлын өдөрт багтаан төрийн сангийн 100050051410 тоот бүртгэлийн дансанд төлнө" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Гэрээгээр 2019 онд олгосон хүлэмжийн 2021 онд төлөгдвөл зохих 1.3 сая төгрөгийн үнийг төлүүлээгүй нь Хүлэмж зээлээр олгох гэрээний 4.2-т "Үлдэгдэл 90%-ийн төлбөрийг 5 жилийн хугацаанд төлнө" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

#### Шатрын сургууль

Үндэслэлгүйгээр 0.1 сая төгрөгийн урамшуулал авсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2-т "Ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил, албан тушаал хавсран буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил, үүргийг гүйцэтгэсэн, шөнийн болон илүү цагаар ажилласан бол үндсэн цалингаас нь тооцон нэмэгдэл хөлс олгоно" Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Тээвэр шатахууны зардлаас 0.2 сая төгрөгийн шатахууны зарцуулалтын анхан шатны баримтгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

#### Насан туршийн боловсролын төв

Ажилчдад 0.5 сая төгрөгийн цалин, нэмэгдлийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1-т "Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хөдөлмөрийн үр дүнд тохируулан олгоно", Төрийн албаны тухай хуулийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

### 4.3 Албан шаардлага

#### Мал хамгаалах сан

Сэлэнгэ үйлдвэрийн 49.5 сая төгрөгийн хээлтүүлэгчийн үхрийн тендерийн шалгаруулах үнэлгээний хороог 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан, тендерийн баримт бичиг дутуу нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т "Захиалагч тендерийн баримт бичгийг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан тендерийн жишиг баримт бичиг, гэрээний

маягт болон тендер шалгаруулалтад холбогдох бусад журам, аргачлалын дагуу бэлтгэнэ" 19.2-т "Тендерийн баримт бичигт тендерт оролцогч зохих шаардлага хангасан тендер бэлтгэж ирүүлэхэд шаардлагатай бүх мэдээлэл, тендерт оролцогчдод тавих шаардлага, тэдэнд өгөх заавар, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, зураг, тендерийн жишиг маягууд, зөвлөх үйлчилгээний хувьд ажлын даалгаврыг тусгана", 47 дугаар зүйл 47.4-т "Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Өмнөх аудитын шийдвэрийн үлдэгдэл 46.9 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулаагүй нь Төрийн аудитын байгууллагын 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 01/34 дугаартай төлбөрийн акт, 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 01/59 дугаартай төлбөрийн акт "Малын үнийг гэрээний дагуу төсөвт төвлөрүүлэх" гэж заасантай нийцэхгүй, батламж мэдэгдлийг хангахгүй байгаа боловч байгууллагын удирдлага солигдсон тул биелэлт ирүүлэх мэдэгдэл хүргүүлээ.

#### Тариалан эрхлэлтийг дэмжих сан

Өмнөх аудитын шийдвэрийн үлдэгдэл 99.2 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулаагүй нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", Төрийн аудитын байгууллагын 2017 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 01/24 дугаартай төлбөрийн акт, 2018 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 01/42 дугаартай төлбөрийн акт, 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 01/35 дугаартай төлбөрийн акт, 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 01/57 дугаартай төлбөрийн акт 1-т "Гэрээт хугацаанд төлөгдөөгүй тракторын үнэ, хүү, алданги, хүлэмжийн үнэ, үрийн төмсний үнэ, жимсний суулгацын үнэ, хүнсний ногооны үрийн үнийг төлүүлж аймгийн Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 100050051410 тоот дансанд төвлөрүүлэх" гэж заасантай нийцэхгүй, батламж мэдэгдлийг хангахгүй байгаа боловч байгууллагын удирдлага солигдсон тул биелэлт ирүүлэх мэдэгдэл хүргүүлээ.

#### Ангилалдаагүй зардал /Аймгийн ЗДТГ-ын 2 дугаар тайлан/

Тайлант онд И баримтгүй 4.2 сая төгрөгийн гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай

хуулийн 14.3-т “Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ” гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Төсвийн хэмнэлтийн горим зөрчиж 47.7 сая төгрөгийг зарцуулсан нь Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.3.-т “төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх”, 1.6-т “Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх”, 1.7-т “хууль тогтоомж, Засгийн газрын албан ёсны шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх;” гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Бизнес эрхлэгчдийн хөгжлийн төвөөс боловсруулсан сан-2021 цахим сайт хийхэд 18.0 сая төгрөг олгосон боловч уг сайт 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрөөс хойш ажиллаагүй нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-т “Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-т “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна” гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Тайлант онд 13.6 сая төгрөгийн бараа материалын тооллого хийгээгүй тооцоо бодсон баримтгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 12.2-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1-т “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 20.2.6-т “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.4-т “комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх” гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Тэтгэвэрт гарсан 13 ажилчдад 19.5 сая төгрөгийн тэтгэмжийг илүү олгосон нь Монгол Улсын Засгийн Газрын 2009 оны 1 дүгээр сарын 9-ны өдрийн 7 дугаар тогтоол Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй туслам олгох журам

1 дүгээр зүйлийн 1.2-т “Эрүүл мэндийн болон боловсролын салбарын хуульд заасан шалгуур, нөхцөлд хамаарах төрийн үйлчилгээний албан хаагч болон төрийн тусгай албан хаагчаас бусад энэ журмын үйлчлэлд хамаарах төрийн албан хаагч нийтдээ 5 жил, үүнээс сүүлийн 3 жил төрийн албанд тасралтгүй ажилласан тохиолдолд нэг удаагийн буцалтгүй тусламж авах эрх үүснэ”, 2 дугаар зүйлийн 2.2-т “Энэ журмын 1.1-д заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдөж, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон төрийн албан хаагчид 2.1-д зааснаар тогтоосон үндсэн цалингийн дунджийг нь төрийн албанд ажилласан нийт жилийн тоотой тэнцэх сарын тоогоор үржүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно. Төрийн албан хаагчид олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийн дээд хэмжээ нь тухайн албан хаагчийн 36 сарын албан тушаалын үндсэн цалингийн дунджаас ихгүй байна” гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

### Шатрын сургууль

Урсгал засварын зардлын 5.0 сая төгрөгийн баримт материал дутуу нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Эдийн засгийн ангилал 2.7 сая төгрөгийн зөрүүтэй нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт “батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах”, Сангийн сайдын 2015 оны "Эдийн засгийн ангилал батлах тухай" 07 дугаар тушаалын 01 дүгээр хавсралттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Санхүүгийн тайлан дахь татварын өглөг, авлага нь татварын тодорхойлолт 0.3 сая төгрөгийн дутуу зөрүүтэй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай нийцээгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Тайлант онд жилийн эцсийн 6.3 сая төгрөгийн хөрөнгийн тооллого хийгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1. жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;/, 20.2.6-т /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;/, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэж заасантай нийцээгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Олон нийтийн Алтай радио

ГАА-2022/01/-НА-СТА-ТЕЗ

Өөрийн орлогын 48 хувийг баяр ёслол, шагналд 2.5 сая төгрөгийг үр ашиггүйгээр зарцуулсан нь Засгийн газрын 2021 оны "төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар" 43 дугаар тогтоолын 1.3-т "төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх" 1.6-т "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Санхүүгийн тайлан дахь татварын өглөг, авлага нь татварын тодорхойлолт 0.1 сая төгрөгийн илүү, 3.0 сая төгрөгийн дутуу зөрүүтэй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай нийцээгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

#### Сум дундын ойн анги

Санхүүгийн тайлан дахь татварын өглөг, авлага нь Татварын тодорхойлолтоос 1.8 сая төгрөгөөр зөрүүтэй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай нийцээгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Төсвийн хэмнэлтийн горим зөрчин 6.9 сая төгрөгийн автомашин бэлтгэсэн нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.4-т "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх;" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

#### Насан туршийн боловсролын төв

Тайлант оны эцэст 2.4 сая төгрөгийн бараа материалыг тооллого хийгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах

тохиолдолд заавал хийнэ"; 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;/, 20.2.6-т /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;/, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэж заасантай нийцээгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Аж ахуйн нэгж, байгууллагаас 1.0 сая төгрөгийн и-баримтгүй худалдан авалт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

#### Ахмадын хороо

Санхүүгийн тайлан дахь татварын өглөг, авлага нь татварын тодорхойлолтоос 1.1 сая төгрөгөөр зөрүүтэй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах";, 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай нийцээгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

#### 4.4 Зөвлөмж

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### Аймгийн Засаг даргад:

#### 1. Арилжааны банкны данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Төсөвт байгууллагууд арилжааны банканд 49 түр данстай байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3-т "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банканд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ.", 35.4-т "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бичгээр ирүүлсэн зөвшөөрөлгүйгээр банк аливаа төсвийн байгууллагад данс нээхийг хориглоно", 35.5-т "Банканд төрийн

сангийн нэгдсэн данснаас гадуур нээсэн төсвийн байгууллагын дансанд тухайн шатны төрийн сан болон төрийн аудитын байгууллага үзлэг, хяналт хийн, энэ хуулийн 35.3-т заасан зөвшөөрөлгүйгээр нээсэн дансыг хаалгах, хөрөнгийг төрийн сангийн нэгдсэн дансанд татан төвлөрүүлнэ." гэж заасны дагуу арилжааны банкны дансны хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, хуулийн хүрээнд шийдвэрлэх

## 2. Цалингийн нөхөн олговортой холбоотой асуудал

- 2.1. Илрүүлэлт: Удирдлагын буруутай шийдвэрийн улмаас 2021 онд 12 ажилтны цалингийн нөхөн олговорт 109.7 сая төгрөгийг төлж төсөв хохироосон
- 2.2. Өгсөн зөвлөмж: Захиргааны ерөнхий хуулийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ.", Хөдөлмөрийн тухай хуулийн 132.1-т "Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцдаа өөрийн буруугаас байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан ажилтанд сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага оногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэнэ.", Төрийн албаны тухай хуулийн 50.1-т "Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ." гэж заасны дагуу төрд учирсан хохирлыг барагдуулах арга хэмжээ авах

### Аймгийн Прокурорын газарт:

#### 1. Сум хөгжүүлэх сангийн зээлдэгч нартай холбоотой асуудал

- 1.1 Илрүүлэлт: 1. Гэрээний хугацаа дууссан 36 зээлдэгчийн 248.2 сая төгрөгийн авлагад шүүхийн шийдвэр гаргуулаагүй.  
2. Эвлэрлийн хугацаа дууссан 22 зээлдэгчийн 79.3 сая төгрөгийн авлагын шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх шүүгчийн захирамж гаргуулаагүй.
- 1.2 Өгсөн зөвлөмж: Монгол улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын хавсралт "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлийн 3.5.3-т "Сумын Засаг дарга нь энэ журмын 3.5.2-т заасан төслийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээдтэй зохих журмын дагуу зээлийн болон барьцааны гэрээ байгуулж, биелэлтийг хангуулах, явц, үр дүнд байнгын хяналт тавьж ажиллах" гэж заасны дагуу хугацаа дууссан зээлийн авлагыг шийдвэр гаргуулах.

### Татварын Ерөнхий Газарт:

#### 1. Татварын тодорхойлолттой холбоотой асуудал

- 1.1 Илрүүлэлт: Төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлан дахь татварын өглөг, авлага нь Татварын тодорхойлолтоос 1,043.3 сая төгрөгөөр зөрүүтэй байна.
- 1.2 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасны дагуу татварын тодорхойлолтын зөрүүг арилгах

### Олон нийтийн Алтай радиод:

ГАА-2022/01/-НА-СТА-ТЕЗ

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

- 1.1 **Илрүүлэлт:** Шилэн дансны цахим системд түүвэрлэн үзэхэд оруулбал зохих 1 төрлийн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 82.1 мянган төгрөгийн орлогын 12 гүйлгээг мэдээлээгүй байна.
- 1.2 **Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ. 6 дугаар зүйл “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтыг мөрдөн ажиллах

Сум дундын ойн ангид:

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

- 1.1. **Илрүүлэлт:** Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 46 мэдээллээс цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 төрлийн 11.0 сая төгрөгийн зарлагын гүйлгээг байршуулаагүй.
- 1.2. **Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ. 6 дугаар зүйл “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтыг мөрдөн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Санхүүгийн тайлангийн аудитын асуудал</b>											
<b>Төсвийн төвлөрүүлэн захирагч</b>											
	Төсвийн ерөнхийлөн захирагч	4	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	4	0.0
<b>Түүвэрт хамрагдсан байгууллага</b>											
	Мал хамгаалах сан	3	51.3	1	1.8	0	0	2	49.5	0	0
	Тариалан эрхлэлтийг дэмжих сан	4	693.6	1	685.3	2	8.3	1	0	0	0
	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан	1	117.6	1	117.6	0	0	0	0	0	0
	Засаг даргын тамгын газрын 2-р	6	95.4	1	10.4	0	0.0	5	85.0	0	0

**Говь-Алтай аймгийн Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

тайлан										
Шатрын сургууль	6	14.6	0	0	2	0.3	4	14.3	0	0
Олон нийтийн Алтай радио	2	5.7	0	0	0	0	2	5.7	0	0
Сум дундын ойн анги	2	8.7	0	0	0	0	2	8.7	0	0
Насан туршийн боловсролын төв	3	3.9	0	0	1	0.5	2	3.4	0	0
Ахмадын хороо	1	1.1	0	0	0	0	1	1.1	0	0
<b>Дүн</b>	<b>32</b>	<b>991.9</b>	<b>4</b>	<b>815.1</b>	<b>5</b>	<b>9.1</b>	<b>19</b>	<b>167.7</b>	<b>4</b>	<b>0.0</b>
<b>Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b>										
<b>Төсвийн төвлөрүүлэн захирагч</b>										
Төсвийн ерөнхийлөн захирагч	0	0	0	0	0	0	0	0	0	0
<b>Дүн</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>Түүвэрт хамрагдсан байгууллага</b>										
Мал хамгаалах сан	0	0	0	0	0	0	0	0	0	0
Тариалан эрхлэлтийг дэмжих сан	0	0	0	0	0	0	0	0	0	0
Засаг даргын тамгын газрын 2-р тайлан	0	0	0	0	0	0	0	0	0	0
Шатрын сургууль	0	0	0	0	0	0	0	0	0	0
Олон нийтийн Алтай радио	1	0	0	0	0	0	0	0	1	0
Сум дундын ойн анги	1	0	0	0	0	0	0	0	1	0
Насан туршийн боловсролын төв	0	0	0	0	0	0	0	0	0	0
Ахмадын хороо	0	0	0	0	0	0	0	0	0	0
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>0</b>
<b>Нийт дүн</b>	<b>34</b>	<b>991.9</b>	<b>4</b>	<b>815.1</b>	<b>5</b>	<b>9.1</b>	<b>19</b>	<b>167.7</b>	<b>6</b>	<b>0.0</b>



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠢᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГА**

Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Жинст баг, 82093  
Утас: 7048-4004, Факс: 7048-3360

2022.04.20 № 1/430

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_ -т

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүгнэлт, шийдвэрийг хүлээн зөвшөөрч байна.

Зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, хугацаанд нь хариуг хүргүүлэх болно.



О.АМГАЛАНБААТАР

*О.Амгаланбаатар*  
Аудитын баримтаар

*[Signature]*

2022.04.20

0304733431